

**ТӨСВИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр, МЯГМАР ГАРАГ

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>1</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-7</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>8-16</i>

1.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	8-11
2.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/	11-13
3.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/	13-16

**Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит бус чуулганы
Төсвийн байнгын хорооны 08 дугаар сарын 27-ны өдөр
/Мягмар гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Төсвийн байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 16 цаг 03 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Т.Аубакир, Р.Батболд, Х.Булгантуяа, З.Мэндсайхан,
Б.Чойжилсүрэн;

Эмнэлгийн чөлөөтэй: Х.Болормаа;

Тасалсан: Н.Алтанхуяг, Ж.Батжаргал, Х.Ганхуяг, Д.Пүрэвдаваа,
Г.Тэмүүлэн.

Нэг.Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Мөнхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан референт О.Мөнгөнчавхдас, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт санал гараагүй болно.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн
42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 3 дугаар зүйлийн “нэрлэсэн дүнгээр гэж” гэсний дараа 19.9 дэх хэсгийн “энэ хуулийн 6.1.2-г” гэснийг “энэ хуульд” гэж тус тус нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн хууль зүйн дүгнэлтийг хэлэлцсэн талаарх Хууль зүйн байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Дав.Цогтбаатар Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 15 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, гурав дахь хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Мөнхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан референт О.Мөнгөнчавхдас, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн талаар Улсын Их Хурлын гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ц.Идэрбат нарын гаргасан, Төслийн 19.1.6.Үүрэн холбооны сүлжээ Хэнтий /Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дэлгэрхаан, Дархан, Баянмөнх сум/ гэсэн төсөл, арга хэмжээний “Дэлгэрхаан” гэснийг “Дадал” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

2.Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Ц.Идэрбат нарын гаргасан, Төслийн 16.2.1.40.Соёл урлагийн цогцолборын барилга, Дундговь, Өндөршил сум гэсэн төсөл, арга хэмжээний “барилга” гэснийг “барилгын нэмэлт санхүүжилт” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

3. Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төслөөс хасах, санхүүжих дүнг бууруулах шинэ төсөл, арга хэмжээ нэмэх, санхүүжих дүнг нэмэгдүүлэх талаар нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналтай уялдуулан төслийн хэрэгжих хугацаанд өөрчлөлт оруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 7
Татгалзсан: 7
Бүгд: 14
50.0 хувийн саналаар дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн П.Ганзоригийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн П.Ганзоригийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14

71.4 хувийн саналаар горимын санал дэмжигдлээ.

Ц.Даваасүрэн: Дээрх дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулъя.

Зөвшөөрсөн: 9

Татгалзсан: 5

Бүгд: 14

64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн П.Ганзориг Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 16 цаг 23 минутад хэлэлцэж дуусав.

Гурав.Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүд /Засгийн газар 2024.08.12-ны өдөр өргөн мэдүүлсэн, эцсийн хэлэлцүүлэг/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Сангийн сайд Б.Жавхлан, Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга М.Санжаадорж, мөн яамны Татварын бодлогын газрын дарга Б.Тэлмүүн, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ж.Дэлгэржаргал, Эдийн засаг, хөгжлийн яамны Макро эдийн засгийн бодлогын газрын дарга Л.Энх-Амгалан, мөн яамны Хөрөнгө оруулалтын бодлогын газрын Төр, хувийн хэвшлийн түншлэлийн хэлтсийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч О.Мөнхтөр нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Зөвлөхүүдийн албаны зөвлөх Б.Төгсцэнгэл, мөн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн дарга Г.Агар-Эрдэнэ, Төсвийн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Э.Алтанзул, Ёс зүй, дэгийн байнгын хороо хариуцсан референт О.Мөнгөнчавхдас, мөн хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн талаар Улсын Их Хурлын гишүүнээс гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулав.

Нэг. Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн дээрх санал дэмжигдсэн учир чиглэл өгөгдсөн Монгол Улсын төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналуудаар санал хураахгүй талаар мэдэгдэв.

Хоёр.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийг хууль санаачлагчид буцаах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдиннямын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцож, 64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Гурав.Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу хураалгах санал:

Ц.Даваасүрэн: 1.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9 дэх хэсгийн “тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл хэмжээгээр хасаж хөнгөлнө.” гэснийг “хасаж хөнгөлнө. Хөнгөлөх дүн нь тухайн татварын жилийн татвар ногдох орлогын 1 хувь хүртэл хэмжээнээс хэтрэхгүй байна.” гэж өөрчлөх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн Б.Батцэцэгийн “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцов.

2.Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.9 дэх заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 8
Татгалзсан: 6
Бүгд: 14
57.1 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн дээрх санал дэмжигдсэн учир Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуулийн 15.1.18, 15.1.19 дэх заалтуудад зохицуулалт хийж, давхардлыг арилгах чиглэл өгөв.

Мөн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлгээс Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.10 дахь заалтын “боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа” гэж өөрчлөх гэсэн саналаа эгүүлэн татсан тухай ирүүлсэн албан бичгийг танилцуулав.

Байнгын хорооны дарга Ц.Даваасүрэн Улсын Их Хурал дахь Ардчилсан намын бүлэг дээрх саналаа татаж авсан тул хуучин томьёоллоор дахин санал хураалт явуулах шаардлагатай талаар тайлбар хийв.

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “22.9.10. төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа” гэж өөрчлөн найруулах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувь буюу нийт гишүүдийн гуравны хоёроор дэмжигдлээ.

Дөрөв.Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар:

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтын дагуу хураалгах санал:

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 1 дүгээр зүйлийн “Цөмийн энергийн тухай хуулийн” гэсний дараа “10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн “шинжлэх ухааны” гэснийг “цөмийн энергийн” гэж,” гэж нэмэх гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 9
Татгалзсан: 5
Бүгд: 14
64.3 хувийн саналаар дэмжигдлээ.

Улсын Их Хурлын гишүүн П.Мөнхтулгын “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дэмжсэнээр тооцов.

“Төрийн өмчийг Нийслэлийн өмчид шилжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулав.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу хураалгах санал:

Ц.Даваасүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэнгийн гаргасан, Төслийн 2 дахь заалтыг хасах гэсэн саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 10
Татгалзсан: 4
Бүгд: 14
71.4 хувь буюу нийт гишүүдийн гуравны хоёроор дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Б.Мөнхсоёл Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулахаар тогтов.

Байнгын хорооны хуралдаанаар 3 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 46 минут үргэлжилж, 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 16 цаг 49 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ТӨСВИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Ц.ДАВААСҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 08 дугаар сарын 27-ны өдөр,
Мягмар гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим,
16 цаг 03 минут

БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ц.Даваасүрэн: Төсвийн байнгын хорооны хуралдаанаа эхэлье, гишүүд ээ. Ирцэд бүртгүүлсэн гишүүдийн нэрс байна уу.

Төсвийн байнгын хорооны гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая.

Байнгын хорооны хуралд оролцох ёстой 25 гишүүнээс 13. Ирц 52 хувьтай байгаа учраас хуралдаанаа эхэлье.

Би хуралдаанд ирсэн гишүүдийн нэрсийг танилцуулъя.

Миний бие, Далайн Батбаяр, Дамбын Батлут, Батмөнхийн Батцэцэг, Жадамбаагийн Баясгалан, Жамбалын Ганбаатар, Гомбын Ганбаатар, Пүрэвжавын Ганзориг, Батжаргалын Заяабал, Баатаржавын Мөнхсоёл, Пүрэвбаатарын Мөнхтулга, Банзрагчийн Түвшин, Даваагийн Цогтбаатар. Мөн Дамдинням гишүүн. Гонгорын Дамдинням гишүүн ирцэд бүртгүүлээрэй.

Ингээд эдгээр гишүүд хуралдаанд оролцож байна. Дамдинням гишүүн бүртгүүлсэн. Хуралдааны ирц 56 хувьтай болсон байна.

Байнгын хорооны гишүүдэд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

1. Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай

хууль болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

2-т, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөл. 3 дахь хэлэлцүүлэг.

3-т, Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийнэ.

Эдгээр хуулийн төслүүд, хэлэлцэх асуудалтай холбогдуулаад саналтай гишүүн байна уу? Алга байна.

Ингээд асуудалдаа оръё. Эхний асуудал.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төслийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг хэлэлцэж эхэлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя.

Ажлын хэсэгт ирснийг нь л танилцуулъя даа. Болдын Жавхлан Сангийн сайд, Мижиддоржийн Санжаадорж Сангийн яамны Төсвийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга, Бямбарагчаагийн Тэлмэн Сангийн яамны Татварын бодлогын газрын дарга, Жамъяншиаравын Дэлгэржаргал Сангийн яамны Санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга, Лхагвабаярын Энх-Амгалан Эдийн засаг, хөгжлийн яамны Макро

эдийн засгийн бодлогын газрын дарга. Эдгээр ажлын хэсгийн гишүүд орж ирнэ шүү. Очиржанцангийн Мөнхтөр Эдийн засаг, хөгжлийн яамны Хөрөнгө оруулалтын газрын Төр, хувийн хэвшил түншлэлийн хэлтсийн даргын үүргийг түүр орлон гүйцэтгэгч. Ийм бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг оролцож байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 24 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 25, 26 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүдийг та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төслүүдтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүд байна уу? Нэрсээ өгье. Асуух асуулттай гишүүн алга байна.

Зарчмын зөрөөтэй саналын томьёолол явах нь дээ.

Төсвийн тогтвортой байдлын хуулийн 19.9-д бас гүйцээн боловсруулах чиглэл өгсөн учраас би, миний гаргасан санал уу. Би зарчмын зөрөөтэй санал хураалгах юм байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу Төслийн 3 дугаар зүйлийн “нэрлэсэн дүнгээр гэж” гэсний дараа 19.9 дэх хэсгийн “энэ хуулийн 6.1.2-т” гэснийг “энэ хуульд” гэж тус тус нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн.

Энэ чинь 3-ны 2-оор уу, үгүй юү? Энэ саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя. Гишүүд ээ, анхаарч байгаарай 19.9-ийн энэ.

Эхлээд ирцийн санал хураалт явуулчихъя, тэгэх үү. Хэдүүлээ нэг шалгаадахъя.

Ирцийн санал хураалт. Хүчингүй болгоё. Техник маань ажиллахгүй байна даа. Манай техникийнхэн бас гишүүдэд туслалцаа үзүүлэхгүй бол. Дахиад хэдүүлээ хяналтын санал хураалт явуулъя. Дахиад.

Санал хураалтаа явуулъя. Миний түрүүний уншсан саналыг дэмжье гэсэн саналын томьёоллоор санал хураалт явуулъя.

Уг саналыг 14 гишүүн оролцоноос 9 дэмжиж, 64,3 хувийн саналаар дэмжигдсэн байна.

Дараагийн санал.

Хамт өргөн мэдүүлсэн Тогтвортой байдлын тухай хуулийн талаар гарсан зарчмын зөрөөтэй саналын томьёоллыг хурааж дууслаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2-т анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрөөтэй санал болон хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо эсхүл бусад хуультай зөрчигдсөн талаарх энэ хуулийн 34.1-д заасан хууль зүйн дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороо дэмжих санал дүгнэлтийг гаргасан тохиолдолд Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа санал хураалт явуулж болно гэж заасан.

Байнгын хорооны санал дүгнэлтийг та бүхэнд тараасан.

Байнгын хорооны санал, дүгнэлтийг Хууль зүйн байнгын санал, дүгнэлтийг Даваагийн Цогтбаатар гишүүн танилцуулъя. Цогтбаатар гишүүн.

Дав.Цогтбаатар: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ, Монгол Улсын Засгийн газраас 2024 оны 08 дугаар сарын 12-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай болон Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдэд хууль зүйн дүгнэлт гаргуулах тухай Төсвийн байнгын хорооны шийдвэрийн дагуу Улсын Их Хурлын Тамгын газар 2024 оны 08 дугаар сарын 22-ны өдөр хууль зүйн дүгнэлт гаргасан.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т холбогдох Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа дараах тохиолдолд санал хураалт явуулж болно.

42.2.2-т анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал болон хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаар энэ хуулийн 34.1-д заасан хууль зүйн дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороо дэмжиж, санал, дүгнэлт гаргасан гэж заасны дагуу Хууль зүйн байнгын хороо 2024 оны 08 дугаар сарын 27-ны өдрийн хуралдаанаараа хэлэлцлээ.

Хууль зүйн дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын дарга Дондогмаа танилцуулсан бөгөөд хууль зүйн дүгнэлт нь нийт 4 асуудлын хүрээнд гарсан байна. Дүгнэлтийн 1 дэх хэсэгт дурдагдсан Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн 2 дугаар зүйлтэй холбоотой асуудлыг нэгтгэн нэгдсэн хуралдаанаараа хэлэлцэх үед Улсын Хурлын дарга гүйцээн боловсруулах чиглэл өгсөн.

Дүгнэлтийн 2, 4 дэх асуудлыг холбогдох ажлын хэсэг болон нам, эвслийн бүлэг зөвшилцөж, зөрчлийг арилгаж, засаж залруулах боломжтой гэж үзсэн.

Иймд Хууль зүйн байнгын хороо Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т заасны дагуу дүгнэлтийн 3 дахь хэсэгт дурдсан Цөмийн нэрийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй холбоотой зөрчлийн талаар хэлэлцсэн болно.

Байнгын хорооны хуралдаанаар дээрх асуудлыг хэлэлцэх үед Улсын Их Хурлын гишүүн Г.Уянгахушиг хууль зүйн дүгнэлтийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаараа хууль зүйн тогтоомжийн төслийг хэлэлцүүлэхээс өмнө хийгдэх ёстой эсэх талаар төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх явцад Хууль зүйн байнгын хороогоор хэлэлцэж байгаа нь хэр үр дүнтэй талаар, Улсын Их Хурлын гишүүн П.Сайнзориг Тамгын газарт хандаж, хууль зүйн дүгнэлт гаргах хүрээ хязгаар болон хууль зүйн техникийн асуудалд анхаарах талаар, мөн цаашид мэргэжлийн Байнгын хорооны хувьд нэгдсэн чуулганаар хэлэлцэж байгаа хууль тогтоомжийн төслүүдийн талаар гаргасан хууль зүйн дүгнэлтийг зөв, буруу эсэхийг шийдвэрлэх хариуцлагатай үүрэг Байнгын хороонд оногдохоор болж байгаа талаар гишүүдэд хандан үг хэллээ.

Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх буюу 64,3 хувь нь Улсын Их Хурлын Тамгын газраас гаргасан хууль зүйн дүгнэлтийг дэмжиж, Төсвийн байнгын хороонд хүргүүлэх нь зүйтэй гэж үзсэн болно.

Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ, Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн хууль зүйн дүгнэлтийг хэлэлцсэн талаар Байнгын хорооны санал,

дүгнэлтийг хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг та бүхнээс хүсье. Баярлалаа.

Ц.Даваасүрэн: Цогтбаатар гишүүнд баярлалаа.

Уг хууль зүйн дүгнэлттэй холбогдоод хууль зүйн дүгнэлтийн дагуу зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулсан талаарх Төсвийн байнгын хорооны танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Цогтбаатар танилцуулчих уу.

Цогтбаатар гишүүн Улсын Их Хурлын нэгдсэн чуулганы хуралдаанд танилцуулна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Өрийн удирдлагын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн эцсийн хэлэлцүүлгүүдийг явуулж дууслаа.

16.15 цаг

Дараагийн асуудалдаа оръё. 2 дахь асуудал.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслүүдийн 3 дугаар хэлэлцүүлгийг эхлүүлье.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсэг хэвээрээ юу? Ажлын хэсгийн бүрэлдэхүүн өмнөх хэлэлцсэн асуудлынхтай ижилхэн юм байна.

Нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган эцсийн хувилбарын танилцуулгын хамтаар та бүхэнд тараасан байгаа.

Эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулаад асуух асуулттай гишүүдийн нэрсийг авъя. Асуух асуулттай гишүүн алга байна.

Санал хураах шатдаа оръё.

Төсвийн төслийн 3 дугаар хэлэлцүүлгээр Байнгын хороо нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган шаардлагатай бол гишүүдээс гаргасан саналын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга, зарчмыг алдагдуулахгүй, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулга хийж, төсвийн төслийн эцсийн хувилбарт тусгах зарчмын зөрөөтэй санал гаргах гишүүн байна уу? Байна.

Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Дарга аа, юу нөгөө энэ дүн, тоотой холбоотой юм 2 дугаар хэлэлцүүлгээс хойш байхгүй болохоор энэ нэг нэр, байршил өөрчлөх тухай л нэг ганц нэг 2 санал байна.

1 дүгээрт, төслийн 19.1.6-д тусгагдсан үүрэн холбооны сүлжээ Хэнтий, Норовлин, Галшар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дэлгэрхаан, Дархан, Баянмөнх сум гэсэн төсөл, арга хэмжээний “Дэлгэрхаан” гэснийг “Дадал” гэж өөрчлөх Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Дамдинням, Ц.Идэрбат.

2 дугаар санал бол Төслийн 16.2.1.40-д тусгагдсан Соёл урлагийн цогцолборын барилга, Дундговь, Өндөршил сум гэсэн төсөл, арга хэмжээний “барилга” гэснийг “барилгын нэмэлт санхүүжилт” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн гээд Дамдинням, Идэрбат. Ийм 2 саналтай байна.

Ц.Даваасүрэн: Тэгвэл Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1. Төслийн 19.1.6-д тусгагдсан үүрэн телефоны сүлжээ Хэнтийн Норовлин, Галшиар, Батноров, Биндэр, Баян-Адарга, Дэлгэрхаан, Дархан, Баянмөнх сум гэсэн төсөл, арга хэмжээний “Дэлгэрхаан” гэснийг “Дадал” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Идэрбат, Г.Дамдинням.

Энэхүү саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Дэмжиж байгаа гишүүд саналаа өгье.

Санал хураалтад 14 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 57,1 хувийн саналаар энэхүү санал дэмжигдсэн байна.

2 дахь санал.

Төслийн 16.2.1.40-д тусгагдсан Соёл урлагийн цогцолборын барилга, Дундговь, Өндөршил сум гэсэн төсөл, арга хэмжээний “барилга” гэснийг “барилгын нэмэлт санхүүжилт” гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Х.Ганхуяг, Г.Дамдинням.

Энэхүү саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Энэ яагаад байна.

Санал хураалтад 14 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 64,3 хувийн саналаар энэ санал дэмжигдсэн байна.

Энэ санал дэмжигдсэн учраас 3 дахь саналыг хураалгая.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төслөөс хасах, санхүүжих дүн бууруулах, шинэ төсөл, арга хэмжээ нэмэх, санхүүжих дүнг нэмэгдүүлэх талаар нэгдсэн хуралдааны 2 дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрөөтэй саналтай уялдуулан төслийг хэрэгжих хугацаанд өөрчлөлт оруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн.

Дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Ганзориг гишүүний микрофоныг өгье.

П.Ганзориг: Миний энэ төхөөрөмж гацаад санал өгч чадсангүй. Уг нь дэмжсэн юм. Тэгээд хүчингүй болгох санал хураалт явуулаад.

Ц.Даваасүрэн: Тэгвэл Ганзориг гишүүний. Мөнхсоёл, Ганзориг гишүүн нарын гаргасан саналын дагуу өмнөх саналыг хүчингүй болгох санал хураалт явуулъя.

14 гишүүн санал өгч, 10 гишүүн дэмжсэн учраас өмнөх санал хураалт 71,4 хувийн саналаар цуцлагдлаа.

Тэгвэл үндсэн санал хураалтаа дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

3 дахь санал хураалтад 14 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 64,3 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Монгол Улсын 24 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн 3 дахь

хэлэлцүүлэгтэй холбогдуулсан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хурааж яваад дууслаа.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 24 оны төсвийн тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх Байнгын хорооноос гаргах танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Ганзориг чуулганд танилцуулна.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндэсний баялгийн сангийн 2024 оны төсвийн тухай хуулийн төслийн 3 дахь хэлэлцүүлгийг явуулж дууслаа.

16.23 цаг

3 дугаар асуудалдаа орно. 3 дахь асуулт.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүн өмнөхөөрөө.

Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслүүдийг та бүхэнд тараасан байгаа.

Эсийн хувилбарын төслүүдтэй холбогдуулаад асуулт асуух гишүүн байна уу? Алга байна.

Асуулт асуух гишүүд алга байгаа учраас санал хураалт явуулъя.

Зарчмын зөрөөтэй саналаар. Санал хураалт явуулъя, гишүүд ээ.

Нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэгтэй уялдуулан Байнгын хороонд шилжүүлсэн асуудлаар санал хураалт явуулж эхэлье.

Эхлээд Төсвийн тухай хууль. Төсвийн тухай хууль дээр Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар гарсан зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу төслийг хууль санаачлагчид нь буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн. Нөгөө Төсвийн хуулийг эцэст нь буцаая гэдэг санал шүү.

Уг саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, 64,3 хувиар уг санал дэмжигдсэн байна.

Энэхүү санал дэмжигдэж байгаа учраас чиглэл өгөгдсөн Монгол Улсын төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн зарчмын зөрөөтэй саналуудыг хураах шаардлагагүй болж байна.

2 дахь санал.

Төрийн болон орон нутгийн өмч хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар

зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу Төслийг хууль санаачлан буцаах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Дамдинням гишүүн дэмжсэн байна.

Хуралдаанд 14 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж 57,1 хувийн саналаар дэмжигдсэн байна.

Энэ дараагийн саналыг хураалгая.

ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

1. Монгол, Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.1 дэх заалтын дагуу Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9 дэх хэсгийн тухайн татварын жилийн татвар ногдох орлогын нэг хувь хүртэл хэмжээгээр хасаж хөнгөлөх гэснийг хасаж хөнгөлнө. Хөнгөлөх дүн нь тухайн татварын жилийн ноогдох орлогын 1 хувь хүртэл хэмжээнээс хэтрэхгүй байна гэж өөрчлөх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Эн санал хураалтад 14 гишүүн оролцож, 8 гишүүн дэмжиж, 57,1 хувийн саналаар дэмжигдсэн байна.

Батцэцэг гишүүний саналыг дэмжсэнээр авлаа.

Дараа нь би нэг санал гаргаж байгаа юм, гишүүд ээ. Зүгээр энэ дээр хэдүүлээ нөгөө виртуал бүсэд мэдээллийн технологийн үйл ажиллагаа явуулж байгаа компанийн татварын хөнгөлөлт 2 болчихоод байгаа гэж би чуулган дээр та бүхэнд танил ...

2 дахь санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 29.9.9 дэх заалтыг хасах. Санал гаргасан. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явъя.

Энэ саналыг 14-өөс 8 гишүүн дэмжиж, 57,1 хувийн саналаар дэмжигдсэн юм байна.

Энэ санал дэмжигдсэн учраас тэр, нөгөө нэг 6 сарын 5-нд батлагдсан гэсэн чинь юуны хууль билээ. 15.1.18, 15.1.19-г саяын энэ санал дэмжигдсэнтэй холбогдуулаад холбогдох хуулийн зохицуулалтуудыг нь хийж, 25 оны төсвийн төсөлд тусгах шаардлагатай боллоо шүү. Тэр нөгөө нэг халамжтай холбогдолтой бас юм байж байгаа тийм ээ? Энэ бүгдийг зохицуулалт хийж, давхардлыг арилгаж оруулж ирэхгүй бол болохгүй боллоо гэдгийг чиглэл өгч байна.

АН-ын бүлгээс, Монгол Улсын Их Хурал дахь Ардчилсан бүлгээс ААНОАТ-ын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаар зарчмын зөрөөтэй санал хүргүүлсэн дараах заалтыг эргүүлэн татаж буйг үүгээр мэдэгдэж байна.

Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.10 дахь заалтын боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа гэж өөрчлөх гэсэн ийм санал байсан шүү дээ. Үүнийгээ буцааж татъя гэж байгаа юм байна.

Ардчилсан намын бүлгийн санал, дүгнэлтийг саналыг тараачхаарай. Гишүүд ээ, одоо Ардчилсан намын бүлгээс саналаа татаж байгаатай холбогдуулаад 22.9.10-ыг нөгөө хуучнаар нь дахин босгох шаардлага гарч байгаа юм.

Ингээд би та бүгдэд саналыг нь томъёоллыг танилцуулна. Та бүхэн энэ саналыг 3-ны 2-оор босгох шаардлагатай болж байна.

Зарчмын зөрөөтэй санал. Төслийн 1 дүгээр зүйлийн 22.9.10-ын төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа гэж өөрчлөн найруулах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн. Саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор. 2 гишүүн дутаад байна гэж байна шүү. Тийм байна. Түвшээг түр дуудчихъя.

Гишүүд ээ, саналыг би уншихсан байж байгаа. Энэ Ардчилсан нам саналаа татсан учраас энэ саналыг бид нар босгох шаардлагатай байгаа. Нөгөө хуучин орж ирсэн хуулийн төслөөрөө босгох шаардлагатай болж байгаа юм. Тэр 3-ны 2-оор босгох хэрэгтэй болсон байна. Нөгөө төрийн болон орон нутгийн өмчийн боловсрол, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаа гэж. Үүнийг оруулахгүй бол заалтгүй болчих гээд байгаа юм шүү.

Тийм учраас энэхүү саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцож, 10 гишүүн дэмжиж, 71,4 буюу 3-ны 2-оор уг санал дэмжигдлээ.

Дараагийн санал.

Гишүүд ээ, Монгол Улсын Их Хурлын чуулганы дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2-т анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрөөтэй санал болон хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо эс үгүй бол бусад хуультай зөрчсөн талаарх энэ хуулийн 34.1-д заасан хууль зүйн дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороо дэмжих санал, дүгнэлт гаргасан тохиолдолд, Цогтбаатар гишүүн танилцуулсан шүү дээ. Гаргасан тохиолдолд холбогдох Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа санал хураалт явуулж болно гэж Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг үзээд

санал, дүгнэлтийг та бүхэнд тараачихсан байгаа.

Тийм учраас би энэ санал, дүгнэлттэй холбогдуулаад Цөмийн энергийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёоллыг хураалгая.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.2 дахь заалтын дагуу Төслийн 1 дүгээр зүйлийн Цөмийн энергийн тухай хуулийн гэсний дараа 10 дугаар зүйлийн 10.2 дахь хэсгийн шинжлэх ухаан гэснийг Цөмийн энергийн гэж нэмэх. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Санал хураалтад 14 гишүүн оролцож, 9 гишүүн дэмжиж, Мөнхтулга гишүүн бас дэмжсэн юм байна тийм ээ. Мөнхтулга гишүүнийг бас дэмжсэнээр авъя.

64,3 хувийн саналаар уг санал дэмжигдсэн байна.

Дараагийн санал.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хураалт дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд санал хураалт явуулах боломжтой.

Дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн зарчмын зөрөөтэй саналын томъёолол гаргах гишүүн байна уу? 1 санал байна.

“Төрийн өмчийг нийслэлийн өмчид илжүүлэх тухай” Улсын Их Хурлын тогтоолын төслийн талаарх зарчмын зөрөөтэй саналын томъёолол.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.2.3 дахь заалтын дагуу Төслийн 2 дахь заалтыг хасах. Санал гаргасан Улсын Их Хурлын гишүүн Ц.Даваасүрэн. Дэмжье гэсэн саналын томъёоллоор санал.

Энэ саналыг би та бүгдэд бас танилцуулъя. “Тавантолгой түши” ХХК-ийн нийслэлийн өмчид шилжүүлэхдээ хуримтлагдсан өр төлбөрийг шийдвэрлэх арга хэмжээг хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж, сайжруулсан түлшний үнийг тогтвортой байлгах шаардлагатай нэмэлт санхүүжилтийг 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр хүртэл шийдвэрлэх арга хэмжээ авахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай гэсэн энэ саналыг хасъя гэж байгаа санал байгаа юм.

Энэ санал 3-ны 2-оор дэмжигдсэн тохиолдолд хасагдана. Энэхүү саналыг дэмжье гэсэн саналын томъёоллоор санал хураалт явуулъя.

Энэхүү саналыг хүчингүй болгоё. Ганбаатар гишүүний микрофоныг өгье.

Энэ чинь нөгөө юу шүү дээ, бид нар нөгөө татаастай нь шилжүүлэх үү, шилжүүлэхгүй юу гээд байгаа шүү дээ. Тэгэхээр нөгөө татаастай нь шилжүүлбэ гэдэг чинь Их Хурал дээр босчихсон шүү дээ. Тэгэхээр тэрийгээ ...

Энэхүү саналыг дэмжье гэдэг саналын томъёоллоор санал хураалт явуулъя. Тэгээд та нар.

Энэхүү саналыг 14 гишүүн оролцож, 10 гишүүн 71,4 хувиар дэмжигдэж, 4-ний 3-аар энэхүү санал дэмжигдсэн байна. 3-ны 2-оор шүү, уучлаарай. 3-ны 2-оор дэмжигдсэн байна.

Дараагийн санал.

Нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн

боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн 3-ны 2-оос доошгүй нь дахин санал хураах шаардлагатай гэж үзсэн тохиолдолд санал хураалт явуулах боломжтой.

Дахин санал хураах шаардлагатай гэж үзэх зарчмын зөрөөтэй саналтай гишүүн байна уу? Алга байна.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын эцсийн хэлэлцүүлэг хэлэлцсэн талаар Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн Мөнхсоёл танилцуулчих уу?

Мөнхсоёл гишүүн Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн хуралдаанд танилцуулъя.

Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслүүдийн эцсийн хэлэлцүүлгийг хийж дууслаа.

16.49 цаг

Гишүүддээ баярлалаа. Том ажлын ард гарлаа.

Ингээд Төсвийн байнгын хорооны өнөөдрийн хуралдаан үүгээр өндөрлөж байна.

Гишүүддээ баярлалаа.

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ

П.ОЮУНГЭРЭЛ